

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04-р сарын 30 өдөр

Дугаар №01/26

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 14.20 цагт Галакси таурын хурлын танхимд эхлүүлэв.

ХЭХурлын дарга: П.Оюунбаяр

Тооллогын комиссын дарга: Д.Даваасүрэн

Тооллогын комиссын гишүүн: Б.Энхдарь

Б.Мөнхтуул нар ажилласан.

Хуралд оролцсон: Монноос ХК-ийн хувьцаа эзэмшигчид:

1. Д.Гиваапилын итгэмжлэлээр Н.Оюунчимэг- 69727ш
2. С.Алимаагийн итгэмжлэлээр Б.Чинчулуун-14443ш
3. Марал импекс ХХК-ийн итгэмжлэлээр Э.Тогосмаа-69824ш
4. Шандас импекс ХХК-ийн итгэмжлэлээр Д.Лхагвасүрэн-20556ш
5. Ариг гал ХК-ийн итгэмжлэлээр-942ш
6. Адам Холдсворд-69824ш /саналын хуудсаар/

Тооллогын комиссын дарга П.Оюунбаяр нь нийтэд гаргасан 350877ш хувьцаанаас 245316ш хувьцаа эзэмшигч буюу 69,9%-ийн саналын эрх бүхий оролцогч оролцсноор хурлыг хүчинтэй гэж мэдээлээд хурлыг эхлүүлсэн.

Хурлын дэгийг ХЭХурлын дарга П.Оюунбаяр танилцуулж, хуралд оролцогчдын 69,9%-ийн саналаар батлав.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Монноос ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх Гүйцэтгэх захирлын тайлан
2. Монноос ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцүүлэх
3. 2025 оны Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
4. ТУЗ-ийн хараат бус болон энгийн гишүүдийг сонгох
5. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцүүлэх

Хурлаар хэлэлцсэн нь:

1. Монноос ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх Гүйцэтгэх захирлын тайланг Ч.Энхцэцэг /Ня-бо/ танилцуулав.

Энхцэцэг /Ня-бо/- Хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдээ өдрийн мэнд хүргэе. 2024 оны Компанийн үйл ажиллагааны тайланг танилцуулья.

“Монноос”ХК нь 2025 онд үндсэн үйл ажиллагаа явуулаагүй болно.

1. “Монноос” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр компанийн бүх үндсэн хөрөнгийг Шунхлай группт худалдан борлуулсан бөгөөд худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн үнэ төлбөрийг авч дуусгавар болсон.
2. “Ариг гал” ХК-аас үзүүлсэн зээлийн эх үүсвэрээр “Монноос” ХК нь үл хөдлөх хөрөнгө болон газрын татвар, бусад орлогоос давсан зардлыг санхүүжүүлснээр үл хөдлөх хөрөнгийн бүрэн бүтэн байдал, газар эзэмших эрхээ хадгалж үлдсэн тул “Ариг гал” ХК-д үндэсний ноолуурын салбарын үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд “Монноос” ХК-ийн хөрөнгө худалдсаны орлогоос өр төлбөрийг нь төлөөд үлдсэн үлдэгдлээс 30,0тэрбум төгрөгийн зээлийг “Ариг гал”ХК-д гэрээний дагуу зээлдүүлсэн болно.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

3. Хөрөнгө борлуулсан орлогоос үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварыг төлөх, олон жилийн хамтын ажиллагаатай компанид мөнгө зээлдүүлэх зэргээр зарцуулсан бөгөөд үлдэгдэл мөнгийг банкинд хугацаатай хадгалуулж, зээлийн хүүгийн болон хадгаламжийн хүүгээр 2025 онд нийт 2,821,5 сая төгрөгийн орлого олж, 2,574,2 сая.төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Мөн нийт 73,6 сая төгрөгийн зардал гаргасан бөгөөд энэ нь өнгөрсөн оныхоос 17,1% буурсан.
4. Компанийн үйл ажиллагааг цаашид хэрхэн сэргээн явуулах асуудлаар судалгаа хийлгэж байгаа. Судалгааны дүгнэлт хараахан гараагүй байна.

Одоо Монноос ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг танилцуулья.

Нэг. Борлуулалтын орлогын талаар

Тус компанийн 2021 оны ХЭХ-ын шийдвэрээр 2022 онд үйлдвэрийн барилга, конторын барилгыг газрын хамт Шунхлай групп-т худалдах гэрээ хэлцэл хийж гэрээний төлбөрийг хэсэгчилэн авч дууссан бөгөөд гэрээнд валютын ханшны өсөлтөөс зөрүүг авахаар заасны дагуу 2025 онд ханшны зөрүүгийн орлого – 1,791.9 сая.төг-ийг авснаар хөрөнгө борлуулсан орлогыг бүрэн авч дээрх компаниудтай тооцоо нийлж дуусгасан. Дээрх хөрөнгө борлуулсны орлогоос үүссэн, татварын өр төлбөрүүдийг барагдуулсан мөн олон жилийн хамтын ажиллагаатай компанид тодорхой хувийн хүүтэй зээлдүүлсэн, зарим сул эх үүсвэрийг банкинд хугацаатай хадгаламж нээлгэн зээлийн хүүгийн орлогоор – 1,192,5 сая.төг-ийн хүүгийн орлого авсан.

Хоёр. Зардлын талаар

2025 онд нийт 73,6 сая.төг-ийн зардал гарсан нь өмнөх оноос 17,1 хувиар буурсан. Зардлын задаргааг харуулбал:

1. Үндсэн үйл ажиллагааны зардал – 73,6 сая.төг нь дараах зардлууд байна. Үүнд:
 - Цалин, НДШимтгэл – 8,6 сая.төг
 - Холбоо, бичиг хэрэг – 0,8 сая.төг
 - БГАҮ-ний зардал – 1,2 сая.төг
 - Түрээс бусад зардал – 63,0 сая.төг

Гурав. Ашгийн талаар

2025 онд бусад орлого буюу хөрөнгө борлуулсны орлогын ханшны зөрүүгийн орлого /НӨАТ-ыг хассанаар/ -1.629,0 сая.төг, хүүгийн орлого 1,192,5 сая.төг- өөс тайлант хугацааны зардалд – 73,6 сая.төг –ийг зарцуулж, 2.747,9 сая төг-ийн ашигтай ажилласан. Энэхүү ашгаас ААНОАТатварын зардал - 173,7 сая.төг -ийг хасаж, 2.574,2 сая.төг –ийн ашигтай ажилласан.

Монноос ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт 307.7 сая төгрөгийн татвар, шимтгэл төлсөн.

Үүнд: НӨАТатварт	- 179.0 сая төгрөг,
ААНОАТатварт	- 92.7 сая төгрөг,
НДШимтгэлд	- 2,9 сая.төгрөг,
Газрын төлбөрт	- 6,5 сая төгрөг,
ХХОАТатварт	- 1,0 сая төгрөг тус тус төлсөн.

Дөрөв. Санхүүгийн байдлын талаар

2025 оны тайлан балансыг харахад авлага өмнөх оноос 33 хувиар өссөн. Энэ Ариг гал ХК-д гэрээний дагуу 6,6 тэрбум төгрөгийг эзэлсэнийг холбоотой.

Дараах авлагууд байгаа. Үүнд :

- | | |
|---|-------------------|
| • Кашмер холдинг ХХК /гэрээний дагуу өгсөн/ | - 7,3 тэрбум.төг |
| • Ариг гал ХК /гэрээний дагуу / | - 32,5 тэрбум.төг |
| • Бусад авлага | - 67,2 сая.төг |

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

• Нийт дүн	- 39,9 тэрбум.төг
2025 оны сүүлээр төлөх өглөгүүд:	
• Бадрах од өгөөж ХХК	- 82,2сая.төг
• Шандас импекс ХХК	- 3,2 тэрбум.төг
• Бусад өглөг	- 56,8 сая.төг
Нийт дүн	- 3,3 тэрбум.төг

Харин татварын өглөгөөс – өмнөх оны үлдэгдэл 77,1 сая.төг болон 2025 онд үүссэн 30,6сая.төгрөгийг төлж, 2025 онд 307,7 сая.төгрөгийг татварыг төлсөн.

2. Монноос ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Оюунбаяр танилцуулав.

Оюунбаяр /ТУЗ-ийн дарга/ - 2025 онд компанийн үйл ажиллагаа бүрэн зогссон байдалтай байсан.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр 2022 онд компанийн бүх үндсэн хөрөнгийг Шунхлай группт худалдан борлуулсан бөгөөд худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн үнэ төлбөрийг авч дууссан.

2025 онд ханшийн зарүүгийн орлого 1629сая.төгрөгийг авснаар хөрөнгө борлуулсан орлогыг бүрэн авч, дээрх компаниудтай тооцоо нийлж дуусгасан байна.

2025 онд нийт 73,6 сая төгрөгийн зардал гаргасан бөгөөд энэ нь өнгөрсөн оныхоос 17,6% буурсан. Тайлант онд 2747,9сая төг-ийн ашигтай ажилласан. Энэхүү ашгаас ААНОАТатварт төлсөн 73,6сая.төг -ийг хасаж, 2574,2сая.төг –ийн цэвэр ашигтай ажилласан.

Монноос ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт 282,1сая төгрөгийн татвар, шимтгэл төлсөн.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааг цаашид хэрхэн сэргээн явуулах асуудлаар судлагаа хийж байгаа. Судалгааны дүгнэлт хараахан гараагүй байгаа.

ТУЗ-өөс Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан нь компанийн өнөөгийн байдлыг бодитой тусгасан гэж үзээд, Компанийн гүйцэтгэх удирдлагаас 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлыг хангалтгүй гэж дүгнэж байна.

Гүйцэтгэх удирдлагын тайлан болон тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

3. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулахыг ТУЗ-ийн нарийн бичиг танилцуулав.

Сансартуяа /ТУЗ-ийн нарийн бичиг/ - ТУЗ-ийн 2026,03,10-ны өдрийн 01/26 тоот тогтоолоор 2025 оны компанийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийг нэгж хувьцаанд 80 төгрөгийг хуваарилж, нийт 28 сая.төгрөгийг зарцуулахыг Гүйцэтгэх захирал Х.Эрдэнбаярт зөвшөөрснийг танилцуулав.

4. ТУЗ-ын хараат бус болон энгийн гишүүдийг сонгох асуудлыг ТУЗ-ийн нарийн бичиг танилцуулав.

Сансартуяа /ТУЗ-ийн нарийн бичиг/ - Та бүхэнд тарааж өгсөн материал дээр ТУЗ-ын гишүүдийн танилцуулга хийгдсэн. ТУЗ-ийн энгийн гишүүнд С.Мөнхжаргал, С.Алимаа, М.Тунгалаг, П.Оюунбаяр, Ж.Болдбаатар нарын, хараат бус гишүүнд Билл Холдсворд, Б.Мэдрээ, И.Сэр-Од, Т.Батмагнай нарын нэр дэвшүүлж байна.

5. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичиг танилцуулав.

Сансартуяа /ТУЗ-ын нарийн бичиг/ - ТУЗ-ийн энгийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн 2026 оны цалингийн зардлын төсвийг оруулж байна. ТУЗ-ийн даргын цалин жилд 800,000 төгрөг, гишүүд, нарийн бичгийн цалин 640,000 төгрөг буюу жилд нийт цалингийн зардлын төсвийг 6,560,000 төгрөгөөр батлуулах санал оруулж байна.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

7.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл

Оюунбаяр /Хурлын дарга/- Одоо хувьцаа эзэмшигчид та бүхэн хэлэлцсэн асуудалтай холбоотой санал, асуултаа тавина уу.

Гиваапил /Хувьцаа эзэмшигч/- 2025 онд үйл ажиллагаа явуулаагүй байж, өндөр ашигтай гарсан нь ямар шалтгаантай байна вэ?

Энхцэцэг /Ня-бо/- Хөрөнгө борлуулах гэрээ хийхдээ долларын ханшийн хэдээс дээш бол зөрүү мөнгийг авна гэсэн заалт хийсэн. 2025 онд ханшийн зөрүүнээс 1,7тэрбум.₮ орлого орж ирсэн.

Алимаа /Хувьцаа эзэмшигч/- Үндсэн үйл ажиллагаа явагдаагүй. Ямар үйл ажиллагаа явуулах гээд байгаа вэ? Мэдээлэл өгнө үү.

Оюунбаяр /Хурлын дарга/- Цэвэр усны бизнесийн судалгаа хийгдэж байгаа. Өөр бас 2 бизнесийн судалгаа хийгдэж байгаа. Тодорхой болоход ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ.

Марал-Импекс/Хувьцаа эзэмшигч/- Эрдэнэбаяр гүйцэтгэх захирлын ажлыг шийдвэрлээгүй байгаа юм уу.

Оюунбаяр /Хурлын дарга/- Гүйцэтгэх захирлын албан тушаалд 2 хүн нэрээ дэвшүүлсэн байсныг ТУЗ-ийн хурлаар оруулж хэлэлцээд, түр түдгэлзүүлсэн байгаа.

8.Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, саналын дүнг гаргаж Тооллогын комиссын дарга Д.Даваасүрэн Хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Д.Даваасүрэн /ТКДарга/- Хуралд 6 саналын 245316 саналын эрхтэй оролцогч санал өгснөөс 6 саналын хуудас бүхий 245316 саналын эрх хүчинтэй тоологдсон.

Тооллогын дүнгээр: Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 245316 санал буюу 100%-ийн саналаар Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг, 245316 санал буюу 100%-ийн саналаар Компанийн 2026 оны удирдлагын зардлын төсвийг 6,560,000 төгрөгөөр батлах санал тоологдов.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, 245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Д.Мөнхбатыг, 245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар С.Алимааг, 245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Ж.Болдбаатарыг, 245316 санал буюу кумулятив 12%-ийн саналаар П.Оюунбаярыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр, 245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Билл Холдсвортыг, 245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар Б.Мэдрээг, 245316 кумулятив санал буюу 11%-ийн саналаар И.Сэр-Одыг, 245316 кумулятив санал 11%-ийн саналаар Т.Батмагнайг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгохыг тус тус тооллогдов.

Оюунбаяр /Хурлын дарга/- Хувьцаа эзэмшигчид хурлыг хаасныг мэдэгдье. Хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа.

ХЭХурлаас гарсан шийдвэр:

1. Монноос ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлав.
2. Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн тогтоолыг дэмжив
3. ТУЗ-ийн энгийн гишүүнээр кумулятив саналаар С.Мөнхжаргал, С.Алимаа, М.Тунгалаг, Ж.Болдбаатар, П.Оюунбаяр нарыг тус тус сонгосныг батлав.
ТУЗ-ийн хараат гишүүнээр кумулятив саналаар Билл Холдсворд, И.Сэр-Од, Б.Мэдрээ, Т.Батмагнай нарыг тус тус сонгосныг батлав.
4. Компанийн 2026 оны удирдлагын зардлын төсвийг 6,560,000 төгрөгөөр батлав.

Тэмдэглэл бичсэн: Хурлын нарийн бичгийн дарга

Зөвшөөрсөн: Хурлын дарга



Сансартуяа Э.Сансартуяа

П.Оюунбаяр